



## ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ НҮТБЬ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2022 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон  
санхүүгийн тайлангийн аудит

Улаанбаатар 2023 он

## АГУУЛГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	2
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	4
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	5
ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
1. БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	9
2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ	10
3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ	12
4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД	12
5. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	19

## Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС3	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТТХ	Санхүүгийн Тайлагналын Тайлбарын Хороо
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
ҮАБО	Үйл ажиллагааны бус орлого

# ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ  
2705958, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо  
Метро бизнес төв А корпус 8 давхар  
Утас факс: 99170900, 70117179  
Email: info@goldenpageaudit.mn

2023. 06. 15 № A/21

танаа \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
ЗӨВЛӨЛ НҮТБЬ-ЫН  
ЗАХИРАЛ Г.ГҮНЖИДМАА  
ТАНАА

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Зөрчилгүй санал дүгнэлт

Бид Хэвлэл мэдээллийн зөвлөл НҮТБЬ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдал, Үр дүн, Цэвэр хөрөнгийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлан болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлан тодруулгад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг талаараа Хэвлэл мэдээллийн зөвлөл НҮТБЬ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдал, Үр дүнгийн тайлан, Цэвэр хөрөнгийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ууд болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомжуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу байгууллагаас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиromжтой гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их анхаарал татсан асуудлууд байдаг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстай. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргах тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авах зориулалтаар гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын үнэлэмжээс хамаарах бөгөөд үүнд залилан юм уу алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилготойгоор аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Хэвлэл мэдээллийн зөвлөл НҮТББ-ын удирдлагуудад зориулан бэлтгэсэн ба бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээнэхгүй.

  
С.Оюунгэрэл  
Огноо: 2023.06.15  
УЗМНВ148 2705958

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

<b>Үзүүлэлт</b>	<b>2021.12.31</b>	<b>2022.12.31</b>
<b>1.Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	184,188,058	98,189,007
Дансны авлага		1,705,326
Бусад авлага	972,040	
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	2,084,399	2,948,799
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>187,244,497</b>	<b>102,843,133</b>
<b>2.Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	34,098,040	42,723,440
Хуримтлагдсан элэгдэл	(15,638,698)	(24,717,503)
Бусад үндсэн хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		
Биет бус хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>18,459,342</b>	<b>18,005,937</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>205,703,838</b>	<b>120,849,069</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>		
<b>1.Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	41,800	687,625
Цалингийн өглөг		1,937,009
Татварын өр	8,757,370	10,750,186
НДШ-ийн өглөг	1,005,986	
Бусад өглөг		142,274
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,805,156</b>	<b>13,517,094</b>
<b>2.Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр		
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>9,805,156</b>	<b>13,517,094</b>
<b>Цэвэр хөрөнгө</b>		
Нөөц: -Хязгаарлалтгүй	30,000	30,000
-Хязгаарлалттай		
Дахин үнэлгээний нэмэгдэл		
Цэвэр хөрөнгийн бусад хэсэг		
Хуримтлагдсан үр дүн	195,868,682	107,301,975
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>195,898,682</b>	<b>107,331,975</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>205,703,838</b>	<b>120,849,069</b>

**ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

<b>Үзүүлэлт</b>	<b>2021.12.31</b>	<b>2022.12.31</b>
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
Гишүүний татвар		
Хөтөлбөр төслийн орлого	603,563,890	656,337,228
Бэлэг хандив, тусламжийн орлого	21,408,325	5,642,495
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>624,972,215</b>	<b>661,979,722</b>
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГА</b>		
<b>Бэлэг, хандив ба тусламж</b>		
а. Байгууллагад өгсөн хандив, тусламж		
б. Хувь хүнд өгсөн хандив, тусламж		
в. Хандив, тусламж хүргэхтэй холбоотой гарсан зардал		
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал		
Төсөл хэрэгжүүлсний зардал	181,067,948	274,490,753
Ерөнхий ба удирдлагын зардал	4,833,209	4,059,480
Цалин хөлс шагнал	190,654,726	354,983,077
Нийгмийн даатгалын шимтгэл	23,066,052	44,481,343
Засвар үйлчилгээний зардал		
Ашиглалтын зардал	414,065	1,017,213
Түрээсийн зардал	23,140,825	15,780,000
Албан томилолтын зардал	910,000	9,379,000
Тээврийн зардал	1,714,400	1,698,774
Элэгдлийн зардал	4,349,474	9,078,805
Зар суртчилгааны зардал		
Шуудан, холбооны зардал	1,991,958	2,276,442
Шатахууны зардал		
Найдваргүй авлагын зардал		
Шагнал, урамшууллын зардал		
Зээлийн хүүгийн зардал		
Бусад зардал	9,591,137	30,460,964
<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн</b>	<b>441,733,795</b>	<b>747,705,852</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны үр дүн</b>	<b>183,238,420</b>	<b>(85,726,130)</b>
<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ</b>	<b>(3,727,868)</b>	<b>(2,840,577)</b>
Туслах, үйлдвэрлэл үйлчилгээний ашиг (алдагдал )		
Торгууль хөнгөлөлтийн ашиг (алдагдал )		
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал )	(3,727,868)	(2,840,577)
Татварын зардал		
Бусад		
<b>Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)</b>	<b>(3,727,868)</b>	<b>(2,840,577)</b>
<b>Тайлант үеийн цэвэр үр дүн</b>	<b>179,510,552</b>	<b>(88,566,707)</b>

### ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хязгаарлалтгүй нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,000</b>	<b>16,358,130</b>	<b>16,388,130</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>30,000</b>	<b>16,358,130</b>	<b>16,388,130</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	179,510,552	<b>179,510,552</b>
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,000</b>	<b>195,868,682</b>	<b>195,898,682</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>30,000</b>	<b>195,868,682</b>	<b>195,898,682</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	(88,566,707)	<b>(88,566,707)</b>
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,000</b>	<b>107,301,975</b>	<b>107,331,975</b>

### МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

<b>Үзүүлэлт</b>	<b>2021.12.31</b>	<b>2022.12.31</b>
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>624,972,215</b>	<b>661,979,722</b>
Гишүүдийн татвараас орсон мөнгө		
Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	603,563,890	656,337,228
Бэлэг, Хандив, Тусlamж	1,920,000	5,642,495
Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө	19,488,325	
Бусад мөнгөн орлого		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>454,394,228</b>	<b>744,830,195</b>
Ажиллагчдад төлсөн мөнгө	193,536,084	291,784,648
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,124,617	79,041,370
Бараа материал худалдан авахад төлсөн	2,087,430	864,400
Ашиглалтын зардалд төлсөн	419,856	940,227
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,764,400	1,698,774
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн	205,138,285	340,522,508
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	10,323,557	29,978,268
Даатгалын төлбөрт төлсөн		
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>170,577,987</b>	<b>(82,850,473)</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого		
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө		
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого		
Худалдаж авсан хөрөнгө оруулалт		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Банкнаас авсан зээл		
Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр		
Зээлийн төлөлт	200,000	
Улсаас өгсөн санхүүжилт		
Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт		
Хүү ба урамшууллын орлого		
Валютын ханшины зөрүү	3,726,283	(2,840,577)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,526,283</b>	<b>(2,840,577)</b>
Валютын ханшийн зөрүү		
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>174,104,269</b>	<b>(85,691,050)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10,083,788</b>	<b>184,188,058</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>184,188,058</b>	<b>98,189,007</b>